Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- Solinst – Water Level meter: Гүний усны түвшин хэмжигч
- WQC24-TDKK-ОА-Одоогоор 30 м хүртлэх гүнд шууд хэмжилт хийх боломжтой
- Solinst – Groundwater sampler (Загвар 425 Дискрет интервал дээжлэгч-100m)

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ХИМИ, ГЕОХИМИЙН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Дэд профессор Ц.Соёл-Эрдэнэ И-мэйл: soyolerdene@seas.num.edu.mn

Зорилго: Хүрээлэн бүй орчны инженерчлэлд геохимийн ойлголт, зарчим, химийн анализыг хэрэглэн, байгалийн бүрэлдэхүүн хэсгүүд дэх бодис, бохирдуулагчдын шилжих, тархах, байгалийн системд нөлөөлөх байдлыг судлах, бохирдлыг үнэлэх, боловсруулах технологи хөгжүүлэх, зүй тогтлыг судлах.

Судалгааны чиглэл:

- Хүрээлэн бүй орчны бохирдуулагчдын шинж чанар
- Бохирдоос сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах, цэвэршүүлэх технологи хөгжүүлэлт
- ХБО-ны шинжилгээний арга хөгжүүлэлт
- Бохирдлын төлөв, нөлөөлөл, тархалт өөрчлөлт

Онцлох үр дүн:

Бага агуулгатай хүрээлэн бүй орчны дээжүүдийг урьдчилан бэлтгэх болон шинжлэх арга зүй боловсруулан нэвтрүүлж хүрээлэн бүй орчны химийн шинжилгээнд үндэслэсэн олон улсын түвшний нарийн судалгаа гүйцэтгэх боломжууд бий болгосон.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **4 өгүүлэл**

Шинэ бүтээлийн патент:

- Хорт бодис/хүнд металлыг шингээх усны ургамлын биосорбент
- Модон хуванцар композит материал болон түүнийг үйлдвэрлэх арга

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **7 төсөл, 379.4 сая төгрөг.**

Ахисан түвшний суралцагч: **10 магистрант, 6 докторант**

Төгсөгч (сүүлийн 2 жилд): **3 магистр**

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- Хийн хроматограф
- Ион хроматограф
- Агаарын тоосонцорын их эзэлхүүнт, бага эзэлхүүнт дээжлэгч



АГААР, ОРЧНЫ МОНИТОРИНГИЙН ЛАБОРАТОРИ

Үдирдагч: Профессор Ч.Сономдагва

И-мэйл: ch_sonomdagva@num.edu.mn

Зорилго: Агаар, орчны чанарын төлөв байдлыг хянах, бохирдол, доройтлыг илрүүлэх, хүний эрүүл мэндэд учрах эрсдлийг тооцоолох

Судалгааны үндсэн чиглэл

- Хүрээлэн буй орчны бохирдлын мониторинг,
- Биологийн олон янз байдлыг хамгаалах, газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх болон нийгмийн инновацын судалгаа

Оншлох үр дүн:

МО-ны хэмжээнд PM2.5 мониторингийн сүлжээ үүсгэж байгаа. Эхний ээлжид Дархан, Эрдэнэт, УБ, Ховд хотуудад судалгааг хийж үр дүнг хэвлүүлсэн.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **10**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **11 төсөл, 1,28 тэрбум төгрөг.**

Ахисан түвшний суралцагч: **12 магистрант, 9 докторант**

Оншлох багаж, тоног төхөөрөмж:

- Dichotomous Monitor / Агаар орчны тоосонцор хэмжигч/
- Dioxin Sampler / Диоксин дээжлэгч/



АГААР МАНДЛЫН ОПТИК ХЭМЖИЛТИЙН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор Ц.Баатарчулуун

И-мэйл: baatarchuluun@num.edu.mn

Зорилго: Агаар мандлын оптик, агаарын бохирдлын үзүүлэлтүүдийг хэмжих, тодорхойлох.

Судалгааны үндсэн чиглэл:

- Агаар мандлын оптик төлөв,
- Агаарын бохирдол,
- Нарны цацрагийн спектр бүтэц,
- Нарны энергийн нөөцийн судалгаа

Онцлох үр дүн:



Олон улсын агаарын бохирдлын ажиглалт, хяналтын SKYNET сүлжээнд нэгдсэн.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **2 өгүүлэл**

Ахисан түвшний суралцагч: **2 докторант**

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- Skyradiometer POM- 01
- Pyrheliometer MS-101 ба нар дагах систем STR-21
- Pyrgeometer PIR



УСАН ОРЧНЫ СУДАЛГААНЫ ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор Н.Сонинхишиг

И-мэйл: soninkhishig@num.edu.mn

Зорилго: Усан экосистем дэх организмуудын (цахиурт замаг, татмын ургамал) бүлгэмдлийн бүтэц, орон зай, цаг хугацааны өөрчлөлтөд үндэслэн усан экосистемийн үйл ажиллагааны төлөв байдал, түүнд хүний үйл ажиллагаанаас үзүүлж байгаа нөлөөллийг үнэлж, усан экосистем, сав газрын байгалийн нөөцийн менежментийг сайжруулахад шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөмж боловсруулах.

Судалгааны үндсэн чиглэл:

Замаг, цахиурын замгийн ангилал зүй, экологи

Татмын ургамалжилт

Лимнологи

Хүрээлэн буй орчны ургац

Усны нөөцийн нэгдсэн менежмент

Оншлох үр дүн:

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд) : **1 төсөл, 119 сая төгрөг.**

Ахисан түвшний суралцагч: **1 магистрант, 1 докторант**

- Хөвсгөл, Бүйр, Тэргийн цагаан, Баруун Монголын томоохон нуурууд, Туул, Хараа зэрэг голууд, Хэнтийн уулсын номхон далайн ай савд хамрагдах газар нутаг, Хөгнө хааны тусгай хамгаалалттай газар зэрэг зарим тодорхой газар нутгийн цахиурт замгийн зүйлийн бүрэлдэхүүнийг тогтоосон
- Шинжлэх ухаанд цахиурт замгийн 70 орчим шинэ зүйлийг нээсэн.
- Цахиурт замгийн бүлгэмдлийн бүтцэд үндэслэн Тэлмэн, Баян нуурын үсны түвшин, орчны бүр нутгийн палео уур амьсгалыг сэргээн тогтоосон.
- Хараа голын сав газрын цахиурт замгийн бүлгэмдлийн бүтцэд үндэслэн газар ашиглалтын олон хэлбэрээс голын экосистемд үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Орхон-Сэлэнгийн сав газрын томоохон голуудын дундаж болон их урсац буурч байгаа нь голуудын татмын нүгүүн ургамал бүрхэвчийн биомасст нөлөөлж, татам хээржиж байгааг илрүүлсэн.

Оншлох багаж, тоног төхөөрөмж:

Гэрлийн микроскоп

• Zeiss PrimoStar 3 маркийн микроскоп

• Fein Optic маркийн микроскоп



ҮРГАМЛЫН БИОТЕХНОЛОГИЙН ЛАБОРАТОРИ

Үдирдагч: Дэд профессор Б.Даваапүрэв

И-мэйл: davaapurev@seas.num.edu.mn

Зорилго: Монгол орны эрс тэс уур амьсгал, хатуу ширүүн нөхцөлд дасан зохицож ургадаг ургамлаас орчны таагүй нөхцөлийг тэсвэрлэх чадвар, хурдан соёололт, богино амьдралын циклийг нөхцөлдүүлэгч генийг олж илрүүлэх, түүний нийлэгжлийг ихэсгэх замаар биомассыг нэмэгдүүлэх, болцыг нь түргэтгэх боломжийг эрэлхийлэх зорилготой судалгааны ажлуудыг хийж байна.

Мөн Монгол орны ургамлаас байгалийн шалгарлын явцад эзэн ургамалтайгаа дасан зохицон амьдарч ирсэн эндофит микроорганизм болох актиномицетийг илрүүлэн, зүйлийн бүрдлийг тогтоон, бактерийн эсрэг идэвх болон антиоксидант идэвхийг судлах. Ургамал болон эндофит актиномицетээс бактерийн эсрэг идэвх үзүүлж буй нэгдлийг ялан, бүтэц байгууламжийг тогтоон, улмаар идэвх үзүүлж буй нэгдэл нь эзэн ургамлын ялгаруулсан бактерийн эсрэг идэвхт нэгдэлтэй ижил эсэхийг тогтоох, тэдгээрийн 16S rRNA генийн дарааллыг тогтоон зүйлийн бүрдлийг илрүүлэн, өсгөврийн сан бүрдүүлэх, судалгааны үр дүн дээр тулгуурлан ургамал болон микроорганизм хоорондын харилцан шүтэлцээг тогтоох, эзэн ургамлуудын удам зүйн холбоог тогтоох зэрэг нь бидний судалгааны ажлын зорилго юм.

Судалгааны үндсэн чиглэл:

- Ургамлын соёололт болон орчны стресс
- Үрийн соёололтын скрининг
- Ургамлын ген шилжүүлэн суулгах
- Эндофит актиномицетийн судалгаа

Оншлох үр дүн:

Гарааны компани байгуулан, Судалгааны үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэхээр бүтээгдэгдэхүүн хөгжүүлэлтийн судалгааг хийж байна:

- UNIQARE, AntiPi, LIVEPRO, AntiCan

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **2**

Патент: **4**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **3 төсөл, 100 сая төгрөг.**

Ахисан түвшний суралцагч: **5 магистрант, 2 докторант**

Төгсөгч (сүүлийн 2 жилд): **3 магистр**



Оншлох багаж, тоног төхөөрөмж:

- Бодит хугацааны полимеразын гинжин урвал
- Флуоресценци микроскоп
- Инвертэд микроскоп
- Биотрон
- Нанодроп
- -80°C-ийн гүн хөлдөөгч
- Ультра центрифуг

БАЙГАЛИЙН НЭГДЛИЙН ХИМИЙН ЛАБОРАТОРИ

Үдирдагч: Профессор Ш.Наранмандах

И-мэйл: smandakh@num.edu.mn

Зорилго.

Байгалийн түүхий эдээс (ургамал, мөөгнөөс) биологийн идэвхт нэгдлийг ялган авах, бүлэглэн хандлах, хроматографийн аргуудаар цэвэршүүлэх, ургамал, мөөг, хүнсний бүтээгдэхүүний химийн үндсэн найрлага агууламжийг химийн болон спектрофотометрийн аргуудаар тодорхойлох.

Судалгааны үндсэн чиглэл:

- Биологийн идэвхтэй байгалийн нэгдлийн фитохимиийн найрлага, бүтцийн судалгаа.
- Мөөгний химийн найрлага, биологийн идэвхийн судалгаа (Микологи).
- Мөөг ба ургамлын полисахаридын найрлага бүтцийн судалгаа (Гликологи).
- Мөөг ба ургамлыг тариалах судалгаа.

Оншлох үр дүн:

- Шинэ бүтээлийн патент: 2
 - Агарцинтай шавар бигнүүр
 - Агил мөөгний бруцеллёзын эсрэг үйлчилгээтэй бэлдмэл, түүнийг бэлтгэх арга
- Ашигтай загвар: 2
 - Шийтаке мөөгийг тариалах арга
 - Бактерийн эсрэг үйлдэлтэй гелин түрхлэг

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **3 өгүүлэл**

Гарааны компани: **1**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **1 төсөл, 28.5 сая төгрөг.**

Ахисан түвшний суралцагч: **3 магистрант, 3 докторант**

Төгсөөгч (сүүлийн 2 жилд): **4 магистр**

Оншлох багаж, тоног төхөөрөмж:

- Хөлдөөн хатаагч (Labconco, Америк)
- Центрифуг (Thermo-scientific, Америк) хөргөлттэй, 15000 эрг//мин
- FPLC уураг түргэн ялгах шингэний хроматографийн систем (Pharmacia, Швед)
- Ферментёр (Ikemoto, Япон)



ХҮНСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор Б.Батжаргал

И-мэйл: batjargal@num.edu.mn

Зорилго

- Амьтан, ургамал, бичил биетний гаралтай биологийн идэвхт нэгдлийн суурь судалгаа
- Биобүтээгдэхүүнийг ялгах цэвэрлэх
- Хүнсний бүтээгдэхүүний биохимиин шинжилгээ
- Инновацийн бүтээгдэхүүн хөгжүүлэх чиглэлээр ахисан түвшний оюутнууд удирдагч багш нарын удирдлагаар судалгааны ажлаа хийх, судалгааны төслүүдийг гүйцэтгэх зорилготой.

Судалгааны чиглэл

- Амьтан ургамлын гаралтай биологийн идэвхт нэгдлийн судалгаа
- Монголын эсэглэн сүүн бүтээгдэхүүнээс сүүнхүчлийн бактери ялгах, тодорхойлох /генийн сан бүрдүүлэх суурь судалгаа/ тэдгээрийн биологийн идэвхийн судалгаа
- Пробиотик идэвхтэй өсгөврүүдийг үйлдвэрлэлд ашиглах боломжийг судлах, бүтээгдэхүүн хөгжүүлэх технологийн судалгаа
- Судалгааны үр дүнд суурилсан шинэ төрлийн инновацийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн судалгаа

Онцлох үр дүн:

Шинэ бүтээлийн патент: 2

- Чацарганы шар буурцгийн синбиотик ундаа үйлдвэрлэх арга
- Шар сүүний антиоксидант идэвхтэй ундаа үйлдвэрлэх арга

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): 1 өгүүлэл

Гарааны компани: 2

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд) : 3 төсөл, 46.9 сая төгрөг.

Ахисан түвшний суралцагч: 6 магистрант, 2 докторант

Төгсөгч (сүүлийн 2 жилд): 6 магистр

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- Real-time PCR /Thermo scientific Piko real 96/
- Elisa reader /Bioteck, ELx808/
- Ultrafiltration system /Spectrum tech/
- Fermentor 10 L /Biobase/
- Evaporation apparatus 10L /Biobase/

ЭМЧИЛГЭЭНИЙ ХҮНС, БАЙГАЛИЙН НЭГДЛИЙН ХИМИЙН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Дэд профессор Б.Мөнхжаргал

И-мэйл: monkjhjargal@num.edu.mn

Зорилго: Монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэг эмийн ба хүнсний ашигт ургамлын гол үйлчлэгч биологи- фармакологийн идэвхт бодисыг нээн илрүүлж, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн гаргах, ургамлын гаралтай – үр тариа болон малын гаралтай түүхий эд сүүнд суурилсан хүнсний үйлдвэрүүд (пиво, спирт, гурил ба сүү)-ийн дайвар буюу хаягдал (пивоны ба спиртийн шаар, ашигласан дрожжи, хивэг, шар сүү)-аас функциональ хүнс, пробиотик, пребиотик, бусад эм биобэлдмэл гаргах, хүн амыг архаг өвчлөлд хүргэж болох хүнсний аюулгүй байдлын эрсдэлтэй эх орны болон импортын хүнсний бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах ахисан түвшний судалгаа гүйцэтгэх зорилготой

Судалгааны үндсэн чиглэл:

- Монголын эмийн болон хүнсний ашигт ургамлын шим тэжээлийн болон биологийн идэвхийг судлах
- Монголын уламжлалт хүнсний шим тэжээл болон биологийн идэвхийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах
- Хүнсний үйлдвэрийн хаягдалиг боловсруулж шинэ төрлийн эмчилгээний шинж чанар бүхий функциональ хүнс гарган авах

Оншлох үр дүн:

Шинэ бүтээлийн патент: 4

- Ангиотензин хувиргагч энзимийг saatuulagch үйлчилгээтэй пептид, түүнийг ялгах болон бэхлэх арга
- Шар сүүнээс лактоз ялгах арга, лактозыг лактулозд хувиргах арга болон тэдгээрийн хэрэглээ
- Ашигласан пивоны дрожжиос бета-глюкоканыг ялгах арга болон түүний хэрэглээ
- Ашигласан пивоны дрожжиос уураг ялгах арга болон түүний хэрэглээ

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **1 төсөл, 30 сая төгрөг**Ахисан түвшний суралцагч: **9 магистрант, 5 докторант**Төгсөгч (сүүлийн 2 жилд): **3 магистр**

Оншлох багаж, тоног төхөөрөмж:

- Хөлдөөн хатаагч, BK-FD10-Series-Vacuum-Freeze-Dryer-table
- Ферментёр, DGF-5L,
- Elisa Reader, Biobase-EL10A
- UV 1000 спектрофотометр, Biobase
- Тоосруулан хатаагч, Mini-Lab-Spray-Dryer-SD-015
- Центрифуг, Thermo-scientific, 15000 эрг/мин



ОЙН ЭКОСИСТЕМИЙН МОНИТОРИНГИЙН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор Н.Баатарбилэг

И-мэйл: baatarbileg@num.edu.mn

Зорилго: Ойн экосистемийн мониторингийн судалгаа – нүүрстөрөгчийн эргэлт, ойн хомсдол доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хий ялгарал, цэвдгийн улирлын өөрчлөлт, тэдгээрийн үр дүнд суурилсан ойг нөхөн сэргээх, ойн байгалийн сэргэн ургалтыг дэмжих биотехнологийн дэвшилтэт технологийг туршин, нутагшуулах, хэрэглээнд нэвтрүүлэх.

Судалгааны үндсэн чиглэл: Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд чиглэсэн судалгааны үндсэн ажлууд

- Ойн экосистемийн нүүрстөрөгчийн солилцоог тодорхойлж, нүүрстөрөгчийн худалдаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх – MJEED
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болсон бүс нутаг, орон нутгийн онцлогт тохирсон, тарьж ургуулах боломжтой модлог ургамлын зүйлийн сонголтын экологи, биологийн үндэс
- Ойн биомассад түшиглэн нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх хэтийн төлөв-MJEED 2027
- Монгол орны ойн модны төрөл зүйлийн тархалтыг уур амьсгалын өөрчлөлтөөс хамааруулан загварчлах нь
- Таримал ойн өсөлтийн шинжилгээнд тулгуурлан ойжуулалтын технологийг боловсруулах

Онцлох үр дүн:

- Ойн экосистемийн мониторингийн судалгааны эхний үр дүнгээ IF-49.962 бүхий Nature сэтгүүлд 2021 онд хэвлүүлсэн.
- Монгол-Америкийн хамтарсан модны жилийн цагирагийн судалгааны үр дүнгээр Төв Азийн Алтай нурууны сүүлийн 800 жилийн температурын өөрчлөлт эрчимтэй дулаарч буй үзэгдлийг хэмжилтийн шинэ арга зүй ашиглан модны жилийн цагирагаар тодорхойлсон.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **5**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд) : **5 төсөл, 211.1 сая төгрөг.**

Ахисан түвшний суралцагч: **6 магистрант, 9 докторант**

Төгсөгч (сүүлийн 2 жилд): **1 доктор**

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- Ойн экосистемийн хийн шингээлт, ялгаруулалтыг хэмжих EDDY FLUX цамхаг
- Мониторинг судалгаанд зориулсан цогц программ хангамж REGENT HORTA SUITE
- Ойн өсөлт бүтээжийг тодорхойлох модны жилийн цагирагийн өсөлтийг хэмжих дижитал систем CDendro-CoRecorder
- Лабораторийн нөхцөлд ургамлын эд эсийн өсгөвөр ургуулах тасалгаа

ОЙН ГЕНЕТИК, ЭКОФИЗИОЛОГИЙН ЛАБОРАТОРИ

Үдирдагч: Профессор Н.Батхүү

И-мэйл: batkhuu@seas.num.edu.mn

Зорилго: Ойн генетик, генетик нөөцийн хамгаалал, ойн селекц, ойн үр судлал, модлог ургамлын генетикийн олон янз байдал, ойн нөхөн сэргээлтийн экофизиологи зэрэг өргөн хүрээний туршилт, судалгааны ажлуудыг гүйцэтгэх.

Судалгааны үндсэн чиглэл:

- Ойн экологи, генетик, физиологийн судалгаа
- Ойн биологийн олон янз байдал, үнэлгээ, хамгаалал,
- Модлог ургамлын генетикийн олон янз байдал
- Ойн генетик нөөцийн хамгаалал, ашиглалт
- Үүр амьсгалын өөрчлөлтөнд ой моддын дасан зохицох, физиологийн хариу үйлчлэл
- Ойн селекц, үржүүлэг, үр судлал, үрийн аж ахуй
- Ойн нөхөн сэргээлтийн экофизиологи Г.М



Оншлох үр дүн:

Тэрбум мод үндэсний хөтөлбөр.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **9**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **2 төсөл, 165.5 сая төгрөг.**

Ахисан түвшний суралцагч: **11 магистрант, 8 докторант**

Төгсөгч: **2 магистр, 1 доктор**



ОПТИК СПЕКТР СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Дэд профессор Г.Эрдэнэ-Очир

И-мэйл: erdeneochir_g@num.edu.mn

Зорилго: Атом, молекулын оптик спектр судал ба нанотехнологи, нано хэмжээт материалын судалгаа, шинжилгээний ажлыг өндөр түвшинд явуулж, эдгээр салбарыг МУИС дээр тасралтгүй хөгжүүлэхэд чиглэнэ.

Судалгааны үндсэн чиглэл:

- Атом, молекулын шингээлтийн спектр дээр үндэслэн төрөл бүрийн хатуу, шингэн дээжийн найрлага ба агуулгыг тодорхойлох тоон болон чанарын анализын шинжилгээг хийх.
- Нано хэмжээт материалын судалгааг хөгжүүлэх. Тус судалгааны баг металл нанопартикл (алт, мөнгө), металл оксид нанопартикл (цайрын оксид, төмрийн оксид), олон ханат нүүрстөрөгчийн нанохоолой зэрэг

Онцлох үр дүн:

Лабораторийн нөөц чадамж, судалгааны багийн үр чадвар дээр суурilan Fe-Co/Al₂O₃ нанокатализаторыг ашиглан CCVD аргаар Олон Ханат Нүүрстөрөгчийн Нано хоолойг гарган авсан.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **1 өгүүлэл**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд) : **1 төсөл, 20 сая төгрөг**

Ахисан түвшний суралцагч: **1 магистрант, 2 докторант**

Онцлох багаж тоног төхөөрөмж

- Thermo iCE 3300 AAS
- Shimadzu UV-2401PC
- Өндөр хурдны центрифуг ВКС-ТН16
- Solaar M5 Atomic absorption spectrometer

/Зориулалт: Эрдэс түүхий эд, төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүн, биологи, геологийн гаралтай органик болон органик бүс дээжүүдэд агуулагдах (Na, K, Mg, Mn, Fe, Co, Ni, Cu, Zn, Pb, Cr гэх мэт) элементүүдийн агуулгыг тодорхойлох/



НАНОМАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор Ч.Ганзориг

И-мэйл: ganzorig@seas.num.edu.mn

Зорилго: Үүсэн байгуулагснаас хойшхи 10 жилийн хугацаанд энэ салбарт чадварлаг ажиллах хүчийг бэлтгэн гаргахыг зорин ажилласан бол дараагийн 10 жилд нийгэм-эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан байгалийн болон биологийн нөөцөд тулгуурласан ахисан түвшний сургалт-судалгаа-инновацийн тогтолцоог хөгжүүлнэ. Үүний хүрээнд эх орны түүхий эд дээр тулгуурласан салбар дундын судалгаа-хөгжүүлэлтийн ажлыг дэвшилтэй судалгааны дэд бүтэц, хүний нөөц, оновчтой менежментэд тулгуурлан хөгжүүлэх, технологи-шингэсэн бүтээгдэхүүнийг дотоодын болон олон улсын зах зээлд гаргах энтрепренер нэгж болохын сацуу олон улсад судлаач, инженер, техникийн ажилтан, технологийн менежерүүдийг тасралтгүй бэлтгэх зорилго тавин ажиллаж байна.

Судалгааны чиглэл

- Дэвшилтэд наноматериалын синтез, хэрэглээ
- Нано биотехнологи, нано-анагаах ухаан
- Нано-электроник, дэвшилтэй багаж төхөөрөмж, үйлдвэрлэл
- Наноматериалын загварчлал, симуляци, компьютер тооцоолол
- Нанотехнологийн стандартчлал, хяналт



Онцлох үр дүн:

Гарааны компани: 1

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): 7 өгүүлэл

Патент: 4

- Ноолуур болон ноолууран бүтээгдэхүүний гадаргууд супер-гидрофоб нано силика нимгэн үе үүсгэх арга
- Сүвэрхэг биш хатуу гадаргуу дээр бактерийн эсрэг идэвхтэй үйлчлэх зэсийн (I) оксидын нанокомпозит бүрхүүл үүсгэх арга
- Соронзон нанопартикл гарган авах арга, түүнийг ашиглан биологийн дээжнээс геномын ДНХ ялгах арга
- Хүнд металлын бохирдол бүхий усыг төмрийн оксидын нано-жижиг хэсгүүдийг (нанопартикл) ашиглан цэвэршүүлэх арга

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): 5 төсөл, 274 сая төгрөг.

Ахисан түвшний суралцагч: 17 магистрант, 12 докторант

Төгсөгч (сүүлийн 2 жилд): 2 магистр

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- UV-Vis spectrophotometer
- Contact angle meter
- Light microscope, Fluorescence microscope, Dark field microscope
- Physical Vapor Deposition (PVD)
- Atomic Force Microscope (AFM)
- Pore size analyzer (Autosorb IQ-C-AG)

ШИНЭ МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИ

Үдирдагч: Профессор Б.Очирхуяг

И-мэйл: ochirkhuyagb@num.edu.mn

Зорилго.

Химийн цэвэр нэгдлүүд болон байгалийн эрдэс түүхий эдэд тулгуурлан тусгай зориулалтын шинэ төрлийн материал гарган авах

Судалгааны чиглэл:

- Шинэ материалын судалгаа,
- Химийн инженерчлэл

Оншлох үр дүн:

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **1**


Патент: **3**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **2 төсөл, 60 сая төгрөг.**

Ахисан түвшний суралшагч: **10 магистрант, 5 докторант**

Судалгааны ажил:

Байгалийн цеолит агуулсан композит материал ашиглан хүнд металлыг усан уусмалаас баганан шингээлтийн аргаар цэвэршүүлэх судалгааны үйл явц.



Оншлох багаж, тоног төхөөрөмж:

- NANOPHOX CS | POLARISATION-SEPARATED BACKSCATTER PCCS
- PLANETARY BALL MILL PM 400
- ZEECOM ZC-3000 | ZETA POTENTIAL & PARTICLE SIZE ANALYZER

ОРГАНИК СИНТЕЗИЙН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Дэл профессор Д.Рэнцэнмядаг

И-мэйл: d_rentsenmyadag@num.edu.mn

Зорилго.

Зэсээр допинг хийсэн цайрын оксидын нанонунтгийн синтезлэх, гарган авсан нанонунтгийн бүтэц болон шинж чанарыг XRD, TEM (HRTEM), EPR, SQUID, UV-Vis, FT-IR багажуудаар тус тус тодорхойлох мөн онолын тооцоолол хийж туршилтын үр дүнтэй харьцуулах. Зэсээр допинг хийсэн цайрын оксидын нанонунтгийн фотокатализтик болон бактерийн эсрэг идэвхийг судлах.

Судалгааны үндсэн чиглэл:

- Нанонунтгийн синтез, онолын тооцоолол болон хэрэглээ
- Соронзон нанонунтгийг ус цэвэршүүлэхэд ашиглах
- Алт болон мөнгөний нанонунтгийн синтез
- Нүүрстөрөгчийн нано хоолойн синтез
- Бэхэлсэн конформаситай амин хүчлийн синтез
- Метал оксид болон метал карбид нанокатализатор ашиглан CVD аргаар нүүрстөрөгчийн нано хоолой гарган авах судалгаа. (ARC 2020-2022)
- Шилжилтийн металаар допинг хийсэн цайрын оксидын нанонунтгийн фотокатализтик болон бактерийн эсрэг идэвхийн судалгаа. (ARC 2028-2020)

Онцлох үр дүн:

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **1 өгүүлэл**

Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр (сүүлийн 2 жил): **1 төсөл, 20 сая төгрөг**

Ахисан түвшний суралцагч: **2 докторант**

Төгсөгч(сүүлийн 2 жилд): **2 магистр**

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- FT-IR (Bruker, Germany)



ЭНЕРГИЙН КАТАЛИЗАТОРЫН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор Б.Энхсаруул

И-мэйл: enkhsaruul_b@num.edu.mn

Зорилго: Цэвэр энергийн технологи хөгжүүлэлтийн судалгааны лаборатори нь нүүрс, занар, нефтийн шатах ашигт малтмалын химийн суурь судалгаа, мөн тэдгээрийн байгальд ээлтэй, дэвшилтэт технологи боловсруулалтын судалгаа ба сургалтын өргөн хүрээтэй үйл ажиллагааг олон улсын түвшинд явуулах үндэсний хэмжээний шинжлэх ухааны байгууллага болох.

Судалгааны үндсэн чиглэл:

- Цэвэр энергийн технологи хөгжүүлэлтийн процессын шинэ төрлийн өндөр идэвхтэй нанокатализаторыг бэлдэх, турших, шинжлэх судалгаа

Онцлох үр дүн:

• Хөдөлгөөнгүй үет уурын риформингийн төхөөрөмжийг Монголд угсарсан.
IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): 7

Патент: 4

- Нүүрсний хийжүүлэлтийг эрчимжүүлэх хос металл агуулсан нүүрсэн катализаторыг бэлтгэх болон хэрэглэх арга. 2020.04.16
- Дээж тогтоогч хоолой бүхий метанжуулалтын хөдөлгөөнгүй давхаргат реакторын бүтэц, ажиллагаа. 2019.01.18
- Метанжуулах процессын нэмэлт металл идэвхжүүлэгчтэй никель катализатор бэлтгэх арга. 2019.01.31
- Нүүрснээс нийлэг хий гарган авах арга. 2014.10.20

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): 4 төсөл, 192,5 сая төгрөг.

Ахисан түвшний суралцагч: 3 магистрант

Төгсөгч (сүүлийн 2 жилд): 1 магистр

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- Хийн хроматограф
- Дифференциал дулааны анализатор
- Хөдөлгөөнгүй үет уурын риформингийн төхөөрөмж



ЭРДЭС ТҮҮХИЙ ЭД, ТҮРШИЛТ СУДАЛГААНЫ ЛАБОРАТОРИ

Үдирдагч: Профессор Д.Эрдэнэчимэг И-мэйл: erdenechimeg_d@num.edu.mn

Зорилго.

Үүл уурхай, боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн боловсруулах хүртэлх технологийн процесс, аналитик контрол, бүхий л асуудал шийдлийг хийж гүйцэтгэх

Судалгааны үндсэн чиглэл

- Металлурги
- Ашигт малтмал, түүхий эд боловсруулалт
- Металлургийн электрохими
- Био-гидрометаллурги
- Хүдэр, баяжмалын исэлдэлт
- Барилга, байгууламжийн бүтэц, эд ангийн зэврэлтийн процесс, зэврэлтээс хамгаалах технологи
- Үйлдвэрийн хоргүйжүүлэлт, хаягдал үс цэвэршүүлэх технологи
- Хүдэр баяжуулах технологи боловсруулах
- Лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн комплекс судалгаа

Оншлох үр дүн:

- Алтыг тиокарбамидын шүлтлэг уусмалд уусгах технологи боловсруулалт
- Зэсийн сульфидийн хүдрийг урьдчилан боловсруулах технологи боловсруулалт
- Бүтэц эд ангийн зэврэлтийн процессыг хянах, материалын зэврэлтийн шинж чанарыг электрохимийн аргаар тодорхойлох технологи боловсруулалт /Монголд ганцхан хийгддэг тоон анализ/

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **7 өгүүлэл**

Патент: **2**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **6 төсөл, 492.3 сая төгрөг.**

Ахисан түвшний суралшагч: **7 магистрант, 5 докторант**

Оншлох багаж, тоног төхөөрөмж:

- ALS2325 Bipotentiostat/Galvanostat /Электрохимийн багаж/
- RRDE-3A Rotating ring disk electrode /Металлургийн термодинамик, кинетик судалгааны багаж/



МАШИН ОЮУНЫ ЛАБОРАТОРИ

Удирдагч: Дэд профессор Ч.Лодойравсал

И-мэйл: lodoiravsal@num.edu.mn

Судалгааны чиглэл: Машин оюуны лаборатори нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг Машин хараа, Эх хэл боловсруулалт, Дүрслэл, Өгөгдөл ба мэдлэгийн инженерчлэл, Роботын чиглэлээр харилцан уялдаатай нэгдмэл судалгаа хийх


Онцлох үр дүн:

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **1 өгүүлэл**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **5 төсөл, 224.7 сая төгрөг**

Ахисан түвшний суралцагч: **1 магистрант, 4 докторант**

Төгсөгч: **1 магистр, 1 доктор**



КОМПЬЮТЕР ГРАФИК, МУЛЬТМЕДИА СУДАЛГААНЫ ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор А.Энхбаяр

И-мэйл: enkhbayar.a@seas.num.edu.mn

Зорилго: Компьютер график, дүрс боловсруулалт, мультимедиагийн чиглэлийн судалгааны ажлыг дэлхийн түвшинд хийж, арга технологи боловсруулах, гаргаж авсан технологийг практикт нэвтрүүлэх.

Судалгааны чиглэл:

- 3D загварчлал
- Компьютер симуляци
- Виртуал реалити
- Аугментэд реалити

Онцлох үр дүн:

Шинэ бүтээлийн патент: 1

- Виртуал симуляторын цогц систем

Ашигтай загвар: 5

- Сургалтын симуляторын удирдлагын систем,
- Олон хэрэглэгч бүхий сургалтын симуляторын цогц систем

Метаверс хөгжүүлэлт - МУИС-тай лицензийн гэрээ байгуулсан.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **2 өгүүлэл**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд) : **4 төсөл, 427 сая төгрөг.**

Ахисан түвшний суралцагч: **11 магистрант, 1 докторант**

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- Lidar sensor
- Mix reality



3D ДЭЛГЭЦ БОЛОН ДҮРС БОЛОВСРУУЛАЛТЫН ЛАБОРАТОРИ

Үдирдагч: Профессор Б.Ганбат

И-мэйл: ganbat@seas.num.edu.mn

Зорилго: Дараа үеийн дэлгэц буюу тусгай зориулалтын шилгүйгээр 3D харах боломжтой дэлгэц болон 3D дүрс боловсруулалтын судалгаа хийх.

Судалгааны чиглэл:

- Гурван хэмжээст дэлгэц, дүрс боловсруулалт
- Агаарт гардаг дэлгэц,
- Холографик дэлгэц,



Онцлох үр дүн:

Шинэ бүтээлийн патент: 2

• Баасанцэрэн Ганбат, Далхaa Номин-Эрдэнэ, "Гурван хэмжээст дэлгэцийн харагдах өнцгийг ихэсгэх арга Method for increasing view angle of three-dimensional display Способ увеличения угла обзора трехмерного экрана," 10-2015-0005563 (5563), 2016.

• Баасанцэрэн Ганбат, Далхaa Номин-Эрдэнэ, "Цэгэн гэрлийн үүсгэгчтэй нийлмэл гурван хэмжээст дүрсийн дэлгэц болон түүний нягтшилийг сайжруулах арга," 10-2017-0005963 (10-0004779), 2019.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **1 өгүүлэл**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **1 төсөл, 43.4 сая төгрөг**

Ахисан түвшний суралцагч: **2 магистрант, 3 докторант**

Төгсөгч: **2 магистр**

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- Stereo 3D дэлгэц
- Агаарт гардаг 3D дэлгэц
- Нийлмэл дүрсийн 3D дэлгэц
- Цэгэн гэрэл үүсгэгч 3D дэлгэц
- Туршилтын оптик ширээ
- Spatial Light Modulator
- Линз, камер
- Нийлмэл дүрсэн дэлгэц



МАТЕМАТИК ХЭРЭГЛЭЭ ТӨВИЙН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор А.Галтбаяр

И-мэйл: galtbayar@num.edu.mn

Зорилго: Монгол улсын нийгэм, эдийн засгийн олон талт асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдэх, математикийн онолын судалгааны үр дүнг практик хэрэглээнд нэвтрүүлэх, практик хэрэглээнээс үүсэн гарч буй боллогуудыг шийдэх замаар математикийн шинжлэх ухааныг хөгжүүлэх.

Судалгааны чиглэл:

- Оновчлол, өгөгдлийн шинжилгээ процессын симуляци
- Компьютер график
- Дүрс боловсруулалт
- Математик загварчлал
- Математик физикийн тэгшитгэл
- Нийлмэл дүрсэн дэлгэц

Оншлох үр дүн:

- Газар тариалангийн боллогууд
- Петровис ХХК – Нөөцийн удирдлага
- Эрдэнэт ҮҮГ – Симуляцийн загварчлал
- Оюутолгой ХХК

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **1**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **2 төсөл, 64.7 сая төгрөг**

Ахисан түвшний суралцагч: **2 докторант**

Төгсөгч: **1 магистр**



СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЛАБОРАТОРИ

Удирдагч: Дэд профессор А.Амарбаяр

И-мэйл: amarbayar@seas.num.edu.mn

Зорилго: Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, технологийн туршилт, судалгаа хөгжүүлэлт.

Судалгааны үндсэн чиглэл:

- Монголд тулгарч буй асуудал бэрхшээлийг инженерчлэлийн ухаанаар судалж, шийдлийг боловсруулан олон нийтэд түгээн дэлгэрүүлэх,
- Утаа, орчны бохирдыг арилгах эрчим хүчний хэмнэлттэй барилгын технологийг Монголын цаг уур, хэрэглээний нөхцөлд тохируулан нутагшуулах судалгаа, хөгжүүлэлт хийх,
- СЭХ-ийг Сонголд зохистой ашиглах арга ухааныг судалж, түгээн дэлгэрүүлэх

Оншлох үр дүн:

Эрчим хүчний хэмнэлттэй “пассив барилга”-ын технологи нутагшуулалтыг амжилттай хэрэгжүүлж байна. ОУ-ын пассив барилгын бүртгэлд Ганданд байрлах 2 давхар 70м² амины сууц эрчим хүчний хэмнэлттэй сууц (LEH)-аар Монгол улсаас анх удаа бүртгэгдсэн.

СЭХ лабораторийн хэмжилт, туршилт, мониторингийн мэдээлэл, анализын үр дүнгээр нотлох баримт болгож бүртгэгдсэн.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): 1

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): 3 төсөл, 9 сая төгрөг.

Ахисан түвшний суралцагч: 3 магистрант

Оншлох багаж, тоног төхөөрөмж:

- Blower Door Tester. Барилгын битүүмжлэлийг хэмжинэ.
- Infra-Red Camera High End model. Барилгын дулааны алдагдлыг зураглана.
- Sun Tracker, Perheliotometer. Нарны шууд болон сарнисан цацрагийг хэмжинэ
- I-V Curve Tracer. Нарны зайн гүйдэл, хүчдэл, чадлыг хэмжинэ



ЧАДЛЫН ЭЛЕКТРОНИКИЙН СУДАЛГААНЫ ЛАБОРАТОРИ

Үдирдагч: Дэл профессор Д.Баясгалан

И-мэйл: bayasgalan@seas.num.edu.mn

Зорилго: Чадлын электроник технологид суурилан эрчим хүчний ухаалаг систем, цахилгаан машин, сэргээгдэх эрчим хүчний системийн судалгаа хөгжүүлэлт.

Судалгааны үндсэн чиглэл

- Чадлын хувиргуур
- Ухаалаг эрчим хүчний сүлжээ
- Эрчим хүчний тархмал систем
- Энерги хуримтлуулах систем

Онцлох үр дүн:

Автомашины хаягдал баттерейг цахилгаан хангамжийн системд ашиглах.


Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд): **4 төсөл, 464.5 сая төгрөг.**

Ахисан түвшний суралцагч: **7 магистрант, 1 докторант**

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

Чадлын электроникийн үндсэн тоног төхөөрөмжийн судалгаа хөгжүүлэлтэд зориулсан иж бүрдэл буюу дараах багажуудаар тоноглогдсон. Үүнд:

- Өндөр хурдны осцилоскоф
- LCR хэмжүүрийн багаж,
- Програмчлагдах тэжээлийн үүсгүүр



ГАЗАР ТӨЛӨВЛӨЛТ, ЗУРАГЛАЫН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор П.Мягмарцэрэн

И-мэйл: myagmartseren@num.edu.mn

Зорилго: Тогтвортой хөгжил байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалт Газар ашиглалтын төлөвлөгөө, судалгаа, зураглал, кадастрын хэмжилт зураглал, газар зохион байгуулалтын ахисан түвшний судалгаа хийх.

Судалгааны чиглэл:

- Хот төлөвлөлт, хотын газарзүй, орон зайн шинжилгээ
- Бэлчээрийн газарзүй, бэлчээрийн менежмент
- Газар ашиглалтын өөрчлөлтийн судалгаа, ГНС-ийн тооллого, бүртгэл зураглал
- З хэмжээст болон олон зориулалтат кадастр, кадастрын зураг
- Газар зохион байгуулалтын бүх түвшний төлөвлөгөө төсөл боловсруулалт
- Геодези, зурагзүйн төсөл боловсруулалт
- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторинг
- Газрын чанарын, хэрэгцээт болон тохиромжтой байдлын үнэлгээ, орон зайн

Оншлох үр дүн:

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **1 өгүүлэл**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд) : **1 төсөл, 10 сая төгрөг**

Ахисан түвшний суралцагч: **3 магистрант, 8 докторант**

Төгсөгч: **1 магистр**

Оншлох багаж, тоног төхөөрөмж:

- Компьютер
- 1 болон 2 долгионы GPS (1 base, 1 rover)
- L2, L1 долгионы GNSS 2 ком
- Total station (Электрон тахеометр)-2 ком
- Жижиг оврын дрон 1
- Электрон теодолит (төмөр хөл, ойлгогчийн таяг, ойлгогч)
- Автомат нивелир



ЗАЙНААС ТАНДАН СУДЛАЛ, ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор В.Батцэнгэл

И-мэйл: battsengel@num.edu.mn

Зорилго: Байгаль орчны хяналт, ирээдүйн экосистемийн ашиг тус, экосистемийн үйлчилгээг сайжруулах, түүнчлэн байгалийн аюулын үед эрсдэлийн менежментийг дэмжихэд дэлхий ажиглалт, тандан судалгааны нарийн арга зүйг боловсруулах.

Оншлох үр дүн:


2021 онд шинээр байгуулагдсан.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **1 өгүүлэл**

Ахисан түвшний суралцагч: **1 докторант**

Судалгааны чиглэл:

- Хот судал
- Байгалийн гамшиг (Түймэр, шар шороон шуурга, цөлжилт, газар хөдлөл, үерийн мониторинг судалгаанууд)
- Бэлчээрийн мониторинг судалгаа
- Газрын доройтол
- Гадаргын ус зүйн мониторинг судалгаа
- Агаар, хөрс, усны хүрээлэн буй орчны бохирдлын судалгаа
- Газар ашиглалт, газрын бүрхэвчийн мониторинг судалгаа



САНСАР СУДЛАЛ, ЗАЙНААС ТАНДАН СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ

Удирдагч: Профессор Р.Цолмон

И-мэйл: tsolmon@num.edu.mn

Зорилго: Сансар судалыг ашиглан байгалийн нөөцийн менежмент ба мониторинг хийх,

- Хиймэл дагуулын өгөгдлийн шинжилгээний онолын болон практикийн хэрэглээг хөгжүүлэх,
- Одон орон ба астрономийг монгол оронд хөгжүүлэх
- Ард иргэдийг шинжлэх ухаанд дуртай болгох, оюунлаг мэдээ мэдээллээр хангах,

Бичил хиймэл дагуулыг хөгжүүлэх,

Хиймэл дагуул бүтээх боловсон хүчнийг бэлтгэх

Судалгааны чиглэл:

- Сансар судал
- Зайнаас тандан судал
- Хиймэл дагуул
- Одон орон судал
- Байгаль орчны суурь судалгаа

Онцлох үр дүн:

- Орон даяар Монгол одонд нэр өгөх арга хэмжээг зохион байгуулсан.
- Монгол улс өөрсдийн одтой болов.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **2**

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр: **1 төсөл, 27.9 сая төгрөг**

Ахисан түвшний суралцагч: **3 магистрант, 3 докторант**

Төгсөгч: **2 магистр, 1 доктор**

Онцлох багаж, тоног төхөөрөмж:

- Prototype /5 separate technique/
- Телескоп



ЛАЗЕРЫН СУДАЛГААНЫ ЛАБОРАТОРИ /ШУС/

Үдирдагч: Профессор Ж.Даваасамбуу

И-мэйл: davaasambuu@num.edu.mn

Зорилго: Хатуу, шингэн болон хийн төлөвт гэрлийн үйлчлэлээр бий болох өдөөгдсөн төлвийн судалгаа, лазерын төхөөрөмжийг хөгжүүлэх, шугаман бус үзэгдэл, квант оптикийн судалгаа, лазерын шинэ материалын судалгааг хийж гүйцэтгэхээс гадна ахисан түвшний суралцагчдыг бэлтгэх зорилготой.

Судалгааны үндсэн чиглэл:

- Фемтосекундын лазерын гэрлийн үйлчлэлээр хатуу, шингэн болон хийн төлөвт үүсэх өдөөгдсөн төлвийн судалгаа
- Богино пульстай лазерын спектроскоп, лазерын төхөөрөмжийн хөгжүүлэлт
- Квант оптикийн судалгаа, шугаман бус үзэгдэл
- Лазерын шинэ материалын судалгаа

Онцлох үр дүн:

- Хэт богино пульстай лазер ашигласан ойлт болон нэвтрэлтийн өдөөн-судлах (pump-probe) стандарт арга болон спектрээс хамаарсан өдөөн-судлах спектрометрийн аргыг хөгжүүлж эхний туршилтуудыг хагас дамжуулагч материалуудад (GaAs, ZnSe) амжилттай хийж гүйцэтгэсэн.
- Лазерын судалгааны төвд өөрсдийн угсарч хийсэн NUM-Ti:Sa лазер
- Гадаргуун плазмоны резонансын үзэгдлийг судлах төхөөрөмж Энэ нь биологийн дээжийг судлахад илүү тохиromжтой бөгөөд бид элэгний делта вирусын оношлогоонд хэрэглэхээр тохируулж байна.

IF өгүүлэл (сүүлийн 2 жилд): **3**Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (сүүлийн 2 жилд) : **6 төсөл, 292.5 сая төгрөг.**Ахисан түвшний суралцагч: **4 магистрант, 2 докторант**Төгсөгч (сүүлийн 2 жилд): **1 магистр**

ГЕНИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ЛАБОРАТОРИ /ХШУИС/

Удирдагч: Дэд профессор О.Одгэрэл

И-мэйл: odgerel@seas.num.edu.mn

Зорилго: Тус лабораторийн зорилго нь Монгол улсад орчин үеийн генетик, молекул биологи, биоинженерчлэл, фармакологи, био-анагаахын судалгаа, хөгжүүлэлтийн томхон төслүүдийг хэрэгжүүлэх, улмаар бий болгосон оюуны баялаг дээрээ тулгуурлан өндөр технологи шингэсэн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх старт-ап компаниудыг өөрөөсөө төрүүлэхэд оршино.

Судалгааны чиглэл:

- Генетик, молекул биологийн суурь судалгааны ажлууд
- Биоинформатик, их өгөгдлийн сангийн анализ
- Байгалийн идэвхт бодисуудыг эрэн хайх, биологийн идэвхийн скрийнинг хийх, үйлчлэлийн механизмыг тодорхойлох

Онцлох үр дүн:

2014 онд байгуулагдсан шагаас хойш Генийн инженерчлэлийн лабораторийн судлаачид эукариот эсийн өсгөврийн санг улам бүр нэмж баяжуулсаар одоогоор нийт 23 нэр төрлийн эсийг агуулж, өөрийн ангилалдаа Монгол улсад байгаа хамгийн том эукариот эсийн өсгөврийн санд тоошогдож байна. Эукариот эсийн өсгөвөр нь молекул биологи, эсийн бологи, биохими, биофизик, генетик, био-анагаах, биотехнологи, эм судал зэрэг судалгааны салбаруудын хамгийн түгээмэл ашиглагддаг, загвар систем юм. Энэхүү эсийн өсгөврийн санг цаашид Монголын бүх судлаачид хамтран ашиглах бүрэн боломжтой.

Онцлох багаж, тоноог:

- Флюресценц, люминесценцийн микроплейт үншигч машин
- Real-Time PCR-ийн термоциклер
- Өндөр хурдны центрифуг
- Гүн хөлдөөгч

